



# УЛААНБААТАР

## хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

Улаанбаатар хот

1982 оны 7 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 147

### ХОГИЙН ЦЭГИЙГ ТОГТООХ ТУХАЙ

Сонгино, БиокOMBинатын орчинд байгаа албан байгууллага, айл өрхүүдийн үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг хаях тогтоосон цэггүйгээс хөрс, усны эх булаг, байгаль орчныг бохирдуулж байгааг зогсоох зорилгоор Хот тохижуулах газар, Ажилчны районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, АЦХС станцын саналыг үндэслэн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. БиокOMBинат дахь Баруун морингийн давааны элсний карьерын газрыг түшиглүүлэн энэ оны 6 дугаар сарын 15-наас эхлэн үйлдвэрийн ба ахуйн хог хаягдлын цэгийг байгуулан хуурай хог хаягдлыг хаяж байхаар тогтоосугай.

2. Ажилчны районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа/н.Ойдовсамбуу/-д даалгах нь:

а/тогтоосон цэгээс өөр газарт хог хаяулахгүй байх талаар хяналт тавьж хогийн цэгийн дотоод журмыг боловсруулж мөрдөх;

б/шинээр нээгдэж байгаа хогийн цэгт Сонгино, БиокOMBинат, Яармаг дахь албан байгууллага, айл өрхүүд хог хаягдлаа зөөж хаях, болсонтой х уялдуулж авто хөсгийн замыг засаж сайжруулах шаардагдах гарц, тэмдгийг байрлуулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авах;

*АДХЗ-ын 1989 оны 161 дүгээр тогтоол*  
3. Шинээр нээсэн хогийн цэгт албан байгууллага, айл өрхөөс гарсан хогийг хаях үйлчилгээний машинд Нисэх дэх бүртгэн өнгөрүүлэх товчоогоор хяналт тавиулж байхыг Улсын авто техникийн хэргийг шалган байцаах газар /н.Рэнчиндорж/-т даалгасугай.

2.

4. Хогийн цэгийн байршил, хил хязгаар, хэтийн төлөв, байгаль орчныг хамгаалах зорилгоор хийгдэх ажлын зураг, схемийг 7 дугаар сарын 15-ны дотор хийж бэлэн бөлгөхыг Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/, Хот тохижуулах газар /н.Бадрах/-т даалгасугай.

5. Хогийн цэгт ажиллах механизмийг нэмэгдүүлж, хогийн цэгийг тохижуулах, тээврийг журамлан хяналт тавих, хог хаягдлыг эмх замбараатай буулгуулан түрж дарах ажлыг зохион байгуулах гурван ээлжийн диспетчерийн орон тоо, цалингийн фондыг батлуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Хот тохижуулах газар /н.Бадрах/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БЛЧГИЙН ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ